



**ХЭНГИЙ АЙМГИЙН
УС, ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ
ТӨВИЙН ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 01 сарын 02 өдөр

Дугаар А/01

Хэрлэн сум


Журам батлах тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.6, 14.7, Монгол улсын Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Ахмадын сайн байгуулах тухай журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн “Ахмадын сангийн ажиллах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Байгууллагын тухайн жилийн батлагдсан төсвийн цалингийн сангийн гурав хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг жил бүрийнхээ төсөвт тусган батлуулж, тус санд шилжүүлж байхыг Ахлан нягтлан бодогч / Г.Нямсүрэн/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Б. ХЭРЛЭНЧИМЭГ

Хэнтий аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний
төвийн 2025 оны 01 дүгээр сарын 25 өдрийн
... дугаар тушаалын хавсралт

УС, ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН АХМАД САНГИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

Ахмад настны тухай хуулийн 14.7, Монгол улсын Засгийн газрын 2017 оны 197 пугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Ахмадын сан байгуулан ажиллах тухай журам"-ын 1.1 дэх заалтыг үндэслэн Ус цаг уур орчны шинжилгээний төвийн "Ахмадын сан" (цаашид "сан" гэх)-г байгуулах, сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах, хяналт тавих үйл ажиллагааг энэ журмаар зохицуулна.

- 1.1. Хэнтий аймгийн Ус, цаг уур орчны шинжилгээний төвд ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэрт гарсан болон ажиллаж байгаа ахмад настанд тэтгэмж, тусламж, дэмжлэг үзүүлэхэд сангийн зорилго оршино.
- 1.2. УЦУОШТ нь үйл ажиллагааны зардлын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны хүрээний олсон орлого, цалингийн нийт сангийн гурав хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг жил бүр санд төвлөрүүлнэ.
- 1.3. Сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах үүргийг байгууллагын удирдлага, сангийн зөвлөлтэй хамтран гүйцэтгэнэ.
- 1.4. Сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах үүргийг байгууллагын дарга хариуцан гүйцэтгэнэ.

Хоёр. Сангийн хөрөнгийн бүрдүүлэлт

- 2.1. Сангийн хөрөнгийг дараахи эх үүсвэрээс бүрдүүлнэ.
 - 2.1.1. Байгууллагын тухайн жилийн батлагдсан төсвөөс цалингийн нийт сангийн 3 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээгээр санд төвлөрүүлсэн хөрөнгө;
 - 2.1.2. Сангийн тухайн жилийн зарцуулагдаагүй үлдэгдэл
 - 2.1.3. Гадаад, дотоодын иргэд байгууллагаас санд өгсөн мөнгөн хандив, мөнгөн бус хандив, тусламжийг борлуулсаны орлого
 - 2.1.4. Бусад эх үүсвэр

Гурав. Сангийн хөрөнгийн зарцуулалт

- 3.1. Сангийн хөрөнгийг Ахмад настны тухай хуулийн 12 дүгээр зүйлийн 12.1, 14 дүгээр зүйлийн 14.6, Монгол улсын Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Ахмадын сан байгуулан ажиллах тухай журам"-ын 3.1-д дагуу дараах арга хэмжээнд зарцуулна.

- 3.1.1. Нийтийн халаалтгүй сууц, гэрт амьдардаг ахмад настанд түлээ, нүүрс худалдан авахад нь жил бүр ЗГ-ын тогтоосон хэмжээгээр дэмжлэг үзүүлэх
- 3.1.2. Ахмад настан өөрөө , түүний нөхөр /эхнэр/ нь нас барсан тохиолдолд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх хэмжээний мөнгөн тусламж үзүүлнэ.
- 3.1.3. Эрүүл мэндийн шалтгаанаар удаан хугацаагаар өвчтэй байгаа ахмад настанд эмчилгээний зардалд зориулж мөнгөн тусламж үзүүлнэ.
- 3.1.4. Ахмадын баяр, Цагаан сарын баярын үед хүндэтгэл үзүүлэх
- 3.1.5. Ахмадуудын дунд идэвхтэй амралт, аялал, урлаг, спортын арга хэмжээ, уралдаан тэмцээн зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;
- 3.1.6. Төрийн дээд, одон медалиар шагнагдсан үед хүндэтгэл үзүүлэх
- 3.1.7. Байгууллагын ахмадын өрөөний тохиожолт, засвар үйлчилгээний зардалд
- 3.2. Сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулахыг хориглоно.
- 3.3. Тус журманд заасан мөнгөн дэмжлэгийг үзүүлэхдээ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 20 хувиас багагүй байхаар тогтооно.
- 3.4. Хурын шим ахмадын холбоо ТББ-ын албан ёсны санал хүсэлтийг үндэслэн байгууллагын удирдлага шийдвэрлэнэ.

Дөрөв. Сангийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих, гүйцэтгэлийн тайлагнал

- 4.1. Сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтад аудитын байгууллага, байгууллагын ахмадын зөвлөл, "Хурын шим" ахмадын хороо ТББ-ын зөвлөл эрх хэмжээнийхээ хүрээнд тус тус хяналт тавина.
- 4.2. Байгууллагын захиргаа нь сангийн орлого, зарлагын жилийн эцсийн гүйцэтгэлийн тайланг дараа оны 02 дугаар сарын 10 дотор гаргаж, "Хурын шим" ахмадын холбоо ТББ-ын гишүүд болон нийт албан хаагчдад тайлагнана.

Тав. Сангийн удирдлага, зохион байгуулалт

- 5.1. Ахмадын сангаас хөрөнгө зарцуулах тухай санал боловсруулах Сангийн зөвлөл байна.
- 5.2. Сангийн зөвлөл нь 5 хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд зөвлөлийн дарга нь Цаг уур орчны технологийн хэлтсийн дарга байна.
 - Байгууллагаас 3 албан хаагч байна. /Цаг уур орчны технологийн хэлтсийн дарга, Мэдээлэл үйлчилгээний хэлтсийн дарга, Хүний нөөцийн асуудал хариуцсан ажилтан/
 - Ахмадын "Хурын шим" ахмадын холбоо ТББ-аас 2 / ТББ-ын дарга, гишүүн/
- 5.3. Сангийн зөвлөл нь энэхүү журмын 3 дугаар зүйлд заасан асуудлыг хэлэлцэж, шийдвэрлэнэ.
- 5.4. Зөвлөлийн хурлыг хүний нөөцийн асуудал хариуцсан ажилтан хөтөлж албажуулна.
- 5.5. Ахмадын сан нь Төрийн санд данстай байна.